



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид үл хөдлөх хөрөнгө
бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, Цэргийн хотхоны 8 дугаар гудамжны 396 тоотод байрлах иргэн Н.Цогбадрахын өмчлөлийн үл хөдлөх хөрөнгө газар чөлөөлөлтөд өртөж нөхөх олговор олгогдсонтой холбогдуулан хавсралтад дурдсан нийт 78,471,000 (далан найман сая дөрвөн зуун далан нэгэн мянга) төгрөгөөр үнэлэгдсэн үл хөдлөх хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн
03 дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Барилга байгууламжийн нэр | Байршил | Талбайн хэмжээ /м2/ | Бүртгэх үнэ /төгрөгөөр/ | Нийслэлийн өмчид бүртгэн авч буй шалтгаан |
|---------------------|------------------------------|--|------------------------|----------------------------|--|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Тоосгон барилга | Баянгол дүүргийн 4 дүгээр хороо, Цэргийн хотхоны 8 дугаар гудамж, 396 тоот | 133 | 60,313,000 | Авто замын нөлөөлөлд өртөж, Нийслэлийн Засаг даргын 2017.06.20-ны өдрийн А/466 дугаар захирамжаар нөхөх олговор нь олгогдсон боловч буугдаагүй үлдсэн тул нийслэлийн өмчид бүртгэн авах |
| 2 | Газар | | 362 | 18,158,000 | |
| Үнэлэгдсэн нийт дүн | | | | 78,471,000 | |